

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/81/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
15 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

2025, 02.25 № 88

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 21,070.5 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 913,145.5 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 43.8 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 57 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр БСУГ-т ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	252,184,071.82	401,544,768.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	170,534,703.56	305,085,497.99
312	Банканд байгаа бэлэн мөнгө	170,534,703.56	305,085,497.99
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	81,649,368.26	96,459,270.84
351	Түүхий эд материал	1,275,250.00	1,906,350.00
3511	Тусгай зориулалттай материал		
3513	Эм боох материал	1,275,250.00	1,906,350.00
354	Хангамжийн материал	80,374,118.26	94,552,920.84
35410	Бичиг хэргийн материал	2,010,680.00	1,284,100.00
35420	Аж ахуйн материал	62,036,973.76	75,636,948.84
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал		
3545	Барилгын засварын материал	646,500.00	7,732,580.00
3546	Хүнсний материал	15,679,964.50	9,899,292.00
35470	Бусад хангамжийн материал		
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,671,698,742.28	1,654,079,304.34
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,671,698,742.28	1,654,079,304.34
392	Биет хөрөнгө	1,205,498,742.08	1,188,129,304.30
39201	Барилга, байгууламж орон сууц	1,298,146,198.87	1,298,146,198.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	(211,911,464.03)	(254,186,784.95)
39203	Авто тээврийн хэрэгсэл		
39204	Хуримтлагдсан элэгдэл		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,373,900.00	64,148,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,041,450.28)	(18,945,700.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,121,650.00	20,210,150.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,595,812.22)	(13,190,570.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	108,119,997.91	108,119,997.91
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,955,209.20)	(19,412,917.68)
39217	Ном	3,240,931.03	3,240,931.03
393	Биет бус хөрөнгө	466,200,000.20	465,950,000.04
39301	Программ хангамж	2,124,300.00	2,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,299.80)	(1,374,299.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	465,200,000.00	465,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,923,882,814.10	2,055,624,073.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,923,882,814.10	2,055,624,073.17
51	Засгийн газрын хувь оролцоо	1,923,882,814.10	2,055,624,073.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	752,956,287.00	752,956,287.00
51101	Өмч: - төрийн	752,956,287.00	752,956,287.00
512	Хуримтлагдсан үр дүн	(186,643,319.98)	(54,902,060.91)
51210	Өмнөх үеийн үр дүн	(186,643,319.98)	(186,643,319.98)
51220	Тайлант үеийн үр дүн	-	131,741,259.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,357,569,847.08	1,357,569,847.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,923,882,814.10	2,055,624,073.17

ХТ05438 @ 8822839

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,125,600,950.00	1,455,201,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,595,950.00	40,245,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,595,950.00	40,245,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,439,000.00	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		5,053,800.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	18,800,000.00	35,157,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	4,356,950.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,100,005,000.00	1,414,955,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,058,050,400.00	1,357,895,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,058,050,400.00	1,357,895,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,954,600.00	57,059,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	41,954,600.00	57,059,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	978,016,967.72	1,323,459,940.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	978,016,967.72	1,323,459,940.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	970,564,054.60	1,321,843,828.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	634,974,030.16	913,145,532.77
210101	Үндсэн цалин	443,579,914.42	641,781,358.77
210102	Нэмэгдэл	174,474,805.74	251,611,862.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	16,919,310.00	19,752,312.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,799,647.51	116,942,570.94
210201	Тэтгэврийн даатгал	55,520,911.77	80,630,005.85
210202	Тэтгэмжийн даатгал	6,531,836.60	9,382,124.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,124,689.24	4,547,493.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,216,158.12	4,427,348.82
210205	Эрүүл мэндийн даатгал	12,406,051.78	17,955,598.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,470,286.88	42,943,387.40
210301	Гэрэл, цахилгаан	6,716,702.13	8,961,254.97
210302	Түлш, халаалт	23,453,115.31	23,366,788.72
210303	Цэвэр, бохир ус	10,300,469.44	10,615,343.71
210304	байрны түрээс		

ХТ05430@0022899

2104	Хангамж, бараа материалын зардал	2,961,743.20	3,459,544.92
210401	Бичиг хэрэг	1,182,330.00	
210408	Бараа материал акталсны зардал	1,779,413.20	3,459,544.92
2105	Нормативт зардал	137,856,967.50	152,995,612.50
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	335,800.00	254,200.00
210502	Хоол хүнс	137,521,167.50	152,741,412.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,586,100.00	5,320,460.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	3,586,100.00	5,320,460.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	3,277,300.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	3,277,300.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,415,279.35	83,759,419.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,459,050.00	12,610,793.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,657,250.00	12,338,388.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,298,979.35	58,810,237.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,452,913.12	1,616,112.60
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,268,600.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,268,600.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	184,313.12	1,616,112.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,313.12	1,616,112.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	147,583,982.28	131,741,259.07
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	147,583,982.28	131,741,259.07



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,102,444,000.00	1,414,990,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,439,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,439,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,439,000.00	35,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,100,005,000.00	1,414,955,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,058,050,400.00	1,357,895,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,058,050,400.00	1,357,895,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,954,600.00	57,059,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,954,600.00	57,059,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	937,460,374.67	1,279,459,605.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	937,460,374.67	1,279,459,605.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	930,007,461.55	1,277,843,492.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	634,974,030.16	913,145,532.77
210101	Үндсэн цалин	443,579,914.42	641,781,358.77
210102	Нэмэгдэл	174,474,805.74	251,611,862.00
210104	Урамшуулал	16,919,310.00	19,752,312.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,799,647.51	116,942,570.94
210201	Тэтгэврийн даатгалын	55,520,911.77	80,630,005.85
210202	Тэтгэмжийн даатгалын	6,531,836.60	9,382,124.89
210203	ҮОМШӨ-ий даатгалын	5,124,689.24	4,547,493.16
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,216,158.12	4,427,348.82
210205	Эрүүл мэндийн даатгалын	12,406,051.78	17,955,598.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,470,286.88	42,943,387.40
210301	Гэрэл, цахилгаан	6,716,702.13	8,961,254.97
210302	Түлш, халаалт	23,453,115.31	23,366,788.72
210303	Цэвэр, бохир ус	10,300,469.44	10,615,343.71
210304	байрны түрээс		
2104	Хангамж, бараа материал	-	-
210401	Бичиг хэргийн зардал		
2105	Нормативт зардал	140,958,097.00	146,815,980.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол хүнс	140,958,097.00	146,815,980.00
2106	Эд хогшил урсгал засвар	1,300,000.00	12,500,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	12,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	3,567,300.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	3,567,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,005,400.00	41,928,721.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,296,250.00	27,500,373.86
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	6,709,150.00	14,428,348.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,452,913.12	1,616,112.60
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-

ХТ06438 @ 9022899

2132	Бусад урсгал шилжүүлэг	7,268,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	7,268,600.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	184,313.12	1,616,112.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,313.12	1,616,112.60
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	164,983,625.33	135,530,794.43
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	3,913,900.00	980,000.00
	Дотоод эх үүсвэр	3,913,900.00	980,000.00
223001	Бусад хөрөнгө	3,913,900.00	980,000.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,913,900.00)	(980,000.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	161,069,725.33	134,550,794.43
31	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл		170,534,703.56
31	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		305,085,497.99



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	752,956,287.00	1,357,569,847.08	(334,227,302.26)		1,776,298,831.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	752,956,287.00	1,357,569,847.08	(334,227,302.26)		1,776,298,831.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			147,583,982.28		147,583,982.28
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	752,956,287.00	1,357,569,847.08	(186,643,319.98)		1,923,882,814.10
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	752,956,287.00	1,357,569,847.08	(186,643,319.98)		1,923,882,814.10
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			131,741,259.07		131,741,259.07
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	752,956,287.00	1,357,569,847.08	(54,902,060.91)		2,055,624,073.17



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,596,257,700.00	1,278,788,492.97	(317,469,207.03)	80.11
21	Урсгал зардлын дүн	1,596,257,700.00	1,278,788,492.97	(317,469,207.03)	80.11
210	Бараа үйлчилгээний зардал	1,596,257,700.00	1,278,788,492.97	(317,469,207.03)	80.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,171,880,300.00	913,145,532.77	(258,734,767.23)	77.92
210101	Үндсэн цалин	858,040,800.00	641,781,358.77	(216,259,441.23)	74.80
210102	Нэмэгдэл	304,922,200.00	251,611,862.00	(53,310,338.00)	82.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	
210104	Урамшуулал	8,917,300.00	19,752,312.00	10,835,012.00	221.51
210105	Гэрээт ажлын хөлс	-		-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,425,800.00	116,942,570.94	(17,483,229.06)	86.99
210201	Тэтгэврийн даатгал	91,412,600.00	80,630,005.85	(10,782,594.15)	88.20
210202	Тэтгэмжийн даатгал	10,751,000.00	9,382,124.89	(1,368,875.11)	87.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,376,900.00	4,547,493.16	(829,406.84)	84.57
210204	Ажилгүйдлийн даатгал	5,376,900.00	4,427,348.82	(949,551.18)	82.34
210205	ЭМД-ын хураамж	21,508,400.00	17,955,598.22	(3,552,801.78)	83.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,327,100.00	42,943,387.40	(12,383,712.60)	77.62
210301	Гэрэл, цахилгаан	12,622,100.00	8,961,254.97	(3,660,845.03)	71.00
210302	Түлш, халаалт	26,319,000.00	23,366,788.72	(2,952,211.28)	88.78
210303	Цэвэр, бохир ус	16,386,000.00	10,615,343.71	(5,770,656.29)	64.78
2105	Нормативт зардал	160,752,000.00	146,815,980.00	(13,936,020.00)	91.33
210502	Хоол хүнс	160,752,000.00	146,815,980.00	(13,936,020.00)	91.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,500,000.00	12,500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	12,500,000.00	12,500,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	5,355,500.00	3,567,300.00	(1,788,200.00)	66.61
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,355,500.00	3,567,300.00	(1,788,200.00)	66.61
210807	Газрын төлбөр				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,017,000.00	42,873,721.86	(13,143,278.14)	76.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,587,600.00	28,445,373.86	(13,142,226.14)	68.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,429,400.00	14,428,348.00	(1,052.00)	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
	Дотоод эх үүсвэрээр				
	Тоног төхөөрөмж				
	Бусад хөрөнгө				

1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,596,257,700.00	1,413,339,287.40	(182,918,412.60)	88.54
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,357,895,900.00	1,357,860,900.00	35,000.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,357,895,900.00	1,357,895,900.00	-	100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,827,100.00	55,443,387.40	(12,383,712.60)	81.74
132001	Орон нутгийн төсвөөс	67,827,100.00	55,443,387.40	(12,383,712.60)	81.74
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	170,534,700.00	35,000.00	170,499,700.00	0.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00	(35,000.00)	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	170,534,700.00		170,534,700.00	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		170,534,703.56	(170,534,703.56)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		305,085,497.99	(305,085,497.99)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
4	АЖИЛЛАГСАДЫН ТОО	48.00	45.00	3.00	93.75
5	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100.00
6	Гүйцэтгэх ажилтан	33.00	32.00	1.00	96.97
7	Үйлчлэх ажилтан	13.00	11.00	2.00	84.62
8	Гэрээт			-	
9	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	403	299	104.00	74.19



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэг нь “Эрүүл чийрэг эерэг хандлагатай, эх оронч монгол иргэн төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл дараах ажиллагаагаа явуулсан байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах
- Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх, цахим хичээл ашиглах
- Суралцагчдын бие даах чадварыг хөгжүүлж, хамтран суралцах үйл ажиллагааг дэмжин ажиллах
- Багш ажилтны ажиллах эрүүл таатай, ээлтэй орчныг бүрдүүлэн ажиллах
- Багш, удирдах ажилтан, ажилчдын ёс зүй, хариуцлага хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дүгээр тушаал “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай”,

Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 115 тоот дугаар тушаал “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам"-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 131,741.26 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	170,534.70	305,085.50	134,550.80
Авлага			-
Бараа материал	81,649.36	96,459.30	14,809.94
Үндсэн хөрөнгө	1,671,698.74	1,654,079.30	(17,619.44)
Нийт хөрөнгө	1,923,882.80	2,055,624.10	131,741.30
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,923,882.80	2,055,624.10	131,741.30
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,923,882.80	2,055,624.10	131,741.30

Тайлант онд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 305,085.5 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,459.3 мянган төгрөг болж 14,809.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,011.2 мянган төгрөгийн эм боох материал, 13,016.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 18,321.9 мянган төгрөгийн аж ахуйн материал, 12,733.7 мянган төгрөгийн барилгын засварын материал, 146,815.9 мянган төгрөгийн

хүнсний материал нийт 191,899.7 мянган төгрөгийн материал бэлтгэн худалдаж авсан ба тайлант онд 13,743.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал 5,647.6 мянган төгрөгийн барилгын засварын материал, 152,596.6 мянган төгрөгийн хүнсний материал, 380.2 мянган төгрөгийн эм боох материал, 1,262.4 мянган төгрөгийн аж ахуйн материал нийт 173,630.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, Цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 12-р сарын 17-ны өдрийн А/23 дугаар тушаалаар 3,459.5 мянган төгрөгийн ашиглах боломжгүй аж ахуйн бараа материалыг акталж, 177,089.8 мянган төгрөгийн материалыг урсгал үйл ажиллагаанд зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,654,079.3 мянган төгрөг болж 17,619.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 980.0 мянган төгрөгийн хөлдөөгч худалдан авч, тайлант хугацаанд Дархан сумын ЗДТГазраас 8,340.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /аяга таваг угаагч/, БШУГазраас багш нарт 26,817.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /14 ш зөөврийн компьютер/, төсвийн хөрөнгөөр 980.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот албан бичгийг үндэслэн 8,399.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээгээр 5,053.8 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэж, Аймгийн засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 1,868.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 60.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил тус тус акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,055,624.1 мянган төгрөг болж 131,741.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,687,430.5 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

2024 оны орон нутгийн төсвийг 67,827.1 мянган төгрөг, Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор улсын төсвөөс 1,357,895.9 мянган төгрөг, болгон нэмэгдүүлж нийт 1,596,257.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхдээ улсын төсвөөс 1,357,895.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 67,827.1 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл 170,534.7 мянган төгрөг буюу нийт 1,596,257.7 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Орон нутгийн төсвөөс 57,059.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 55,443.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 1,616.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, улсын төсвөөс 1,357,895.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 1,223,345.1 мянган төгрөгийг зарцуулж, 134,550.8 мянган төгрөг зарцуулаагүй үлдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,278,788.5 мянган төгрөг буюу 80.1 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 317,469.2 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801-Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	81605- Эрүүл мэндийг дэмжих	6,341.0	1,876.0	(4,465.0)	29.6%
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	160,752.0	146,816.0	(13,936.0)	91.3%
1.3	80233-Хүүхэд хамгаалал	2,170.2	2,170.2	-	100.0%
1.4	81834- Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,343,161.0	1,058,573.3	(284,587.7)	78.8%
1.5	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	6,235.6	6,235.6	-	100.0%
1.6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	6,441.0	6,414.0	(27.0)	99.6%
1.7	81823-Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	3,329.8	1,260.0	(2,069.8)	37.8%
1.8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	67,827.1	55,443.4	(12,383.7)	81.7%
Нийт дүн		1,596,257.7	1,278,788.5	(317,469.2)	80.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 33 ажилтан, үйлчлэх 11 ажилтан буюу нийт 45 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 27,500.4 мянган төгрөгийг зарцуулж, тайлант онд хүүхдийн хоол хүнсний материалыг худалдан авахтай холбоотой 6 багцад 142,407.4 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт явуулахад “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ” багцад нэг оролцогч ирж шалгарсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд хүүхдийн хоол хүнсний материалыг худалдан авахтай холбоотой 6 багцад 142,407.4 мянган төгрөгийн нээлттэй тендерийг нийт 6 удаа зарлахад “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ” багцад “Өмнө Чонос” ХХК шалгарч, бусад багцуудад оролцогч ирээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 978,016.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,780.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус цэцэрлэгийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан 1,249,397.8 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 108,498.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 156,757.9 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 80.1 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Мөн аудитаар нийт 3,088.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 3,088.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тайлант онд 3,088.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-тай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмж өгөөгүй.

Дээрх зөвлөмж болон 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/													
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан	Заглуулаагүй						
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/													
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус цэцэрлэгийн эрхлэгч С.Энхцэцэгийг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 2 дахин нэмэгдүүлэн 3,088.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	3,088.0			1	3,088.0								
Дүн	1	3,088.0	-	-	1	3,088.0	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэг нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-